



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/096/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэбулган хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг
Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 131
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
З.МӨНХЗУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,447,207.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 148,963.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,596,171.1 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 35,912.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 450.0 мянган төгрөгийн программ хангамж, Эрүүл мэндийн яамнаас 27,385.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн газраас 32,475.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 27,053.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 85.2 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>158,398,117.17</u>	<u>222,885,500.24</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	652,065.87	35,912,601.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	652,065.87	35,912,601.40
3121	Төгрөг	652,065.87	35,912,601.40
31211	Төрийн сангийн харилцах	652,065.87	35,912,601.40
33	АВЛАГА	120,403,226.39	153,103,623.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	115,576,861.39	153,103,623.30
35	БАРАА МАТЕРИАЛ	37,342,824.91	33,869,275.54
351	Түүхий эд материал	36,449,695.41	30,511,149.54
35130	Эм боох материал	36,449,695.41	30,511,149.54
354	Хангамжийн материал	893,129.50	3,358,126.00
35410	Бичиг хэргийн материал	182,000.00	16,500.00
35460	Хүнсний материал	711,129.50	3,341,626.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,689,693,714.18</u>	<u>2,650,734,859.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,689,693,714.18	2,650,734,859.53
392	Биет хөрөнгө	2,657,175,714.18	2,617,766,859.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,452,809,933.30	2,452,809,933.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(209,034,651.30)	(253,840,367.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,379,547.30	266,379,547.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,954,911.60)	(125,361,467.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	489,684,401.85	334,818,257.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(259,099,271.65)	(61,866,723.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,387,751.00	10,746,134.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,997,084.72)	(5,918,453.68)
393	Биет бус хөрөнгө	32,518,000.00	32,968,000.00
39301	Програм хангамж	-	450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,518,000.00	32,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,848,091,831.35</u>	<u>2,873,620,359.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>83,473,793.85</u>	<u>2,524,559.18</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	83,473,793.85	2,524,559.18
413	Өглөг	83,473,793.85	2,524,559.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	628,342.62	2,524,559.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,764,618,037.50</u>	<u>2,871,095,800.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,764,618,037.50	2,871,095,800.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	727,738,725.60	727,738,725.60
51101	Өмч: - төрийн	727,738,725.60	727,738,725.60
512	Хуримтлагдсан үр дүн	1,521,474,396.41	1,628,241,321.72
51210	Өмнөх үеийн үр дүн	1,521,474,396.41	1,521,763,558.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	106,477,763.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	515,404,915.49	515,115,753.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,848,091,831.35</u>	<u>2,873,620,359.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,480,383,085.06	1,816,689,544.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,500,000.00	90,474,466.41
120	Нийтлэг татварын бус орлого	43,500,000.00	90,474,466.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,500,000.00	59,860,864.54
100017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	59,860,864.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		27,053,601.87
120009	Бусад орлого	-	3,560,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,436,883,085.06	1,726,215,078.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,804,800.00	148,963,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,804,800.00	148,963,800.00
1330	Төсвийн захирагчдаас	-	92,517,184.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	92,517,184.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,280,078,285.06	1,484,734,094.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,280,078,285.06	1,484,734,094.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,506,596,050.50	1,710,147,758.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,506,596,050.50	1,710,147,758.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,506,596,050.50	1,612,455,205.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	895,982,208.00	1,033,220,775.19
210101	Үндсэн цалин	565,226,755.00	527,772,535.10
210102	Нэмэгдэл	256,693,353.00	420,276,493.09
210104	Урамшуулал	74,062,100.00	85,171,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,955,000.33	135,228,453.24
210201	Тэтгэврийн даатгал	78,682,464.98	90,959,053.73
210202	Тэтгэмжийн даатгал	9,195,074.47	11,067,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,535,014.34	5,533,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,308,488.72	5,533,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,233,957.82	22,134,599.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,764,107.32	140,346,859.18
210301	Гэрэл, цахилгаан	8,601,587.32	10,194,882.82
210302	Түлш, халаалт	134,502,520.00	118,806,156.36
210303	Цэвэр, бохир ус	11,660,000.00	11,345,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,724,380.00	43,987,270.00
210401	Бичиг хэрэг	7,942,900.00	8,481,000.00
210402	Тээвэр, шатахуун	35,215,633.00	23,987,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,748,100.00	5,813,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,231,870.00	5,285,100.00
2105	Нормативт зардал	97,959,730.97	110,109,629.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	81,418,925.47	85,922,028.72

210502	Хоол, хүнс	16,540,805.50	21,517,601.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,670,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,041,122.68	20,893,222.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,688,072.68	4,000,000.00
210604	Урсгал засвар	5,353,050.00	16,893,222.50
2107	Томиллолт, зочны зардал	3,030,500.00	7,100,000.00
210702	Дотоод албан томиллолт	3,030,500.00	7,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,801,500.00	20,844,776.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,101,500.00	19,132,276.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	212,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,337,501.20	100,724,219.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,292,600.00	1,454,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,044,901.20	99,269,719.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	97,692,553.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	94,730,053.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,829,053.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,052,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,849,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,962,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,962,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(26,212,965.44)	106,541,786.09
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	(64,023.00)
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		(64,023.00)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(64,023.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(26,212,965.44)	106,477,763.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,416,609,346.67	1,692,248,316.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,500,000.00	3,560,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,500,000.00	3,560,000.00
120009	Бусад орлого	-	3,560,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,373,109,346.67	1,688,688,316.59
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	156,804,800.00	148,963,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	156,804,800.00	148,963,800.00
1330	Төсвийн захирагчдаас	-	102,900,084.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	102,900,084.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,216,304,546.67	1,436,824,432.59
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,216,304,546.67	1,436,824,432.59
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,416,573,481.00	1,656,627,781.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,416,573,481.00	1,656,627,781.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,416,573,481.00	1,558,935,227.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	875,725,882.32	1,105,968,026.42
210101	Үндсэн цалин	540,010,222.00	601,786,151.33
210102	Нэмэгдэл	264,376,444.32	419,010,128.09
210104	Урамшуулал	71,339,216.00	85,171,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,529,734.68	135,228,453.24
210201	Тэтгэврийн даатгал	66,178,916.38	90,959,053.73
210202	Тэтгэмжийн даатгал	7,839,360.99	11,067,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,920,191.89	5,533,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,912,874.83	5,533,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,678,390.59	22,134,599.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,804,800.00	138,333,800.00
210301	Гэрэл, цахилгаан	7,395,694.79	10,194,882.82
210302	Түлш, халаалт	127,409,105.21	116,793,097.18
210303	Цэвэр, бохир ус	12,000,000.00	11,345,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,515,093.00	42,850,183.00
210401	Бичиг хэрэг	6,072,100.00	9,288,200.00
210402	Тээвэр, шатахуун	30,053,070.00	21,883,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,927,500.00	7,405,740.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,648,003.00	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,814,420.00	3,852,313.00
2105	Нормативт зардал	149,950,541.00	78,831,564.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,390,641.00	54,436,725.00
210502	Хоол, хүнс	22,938,600.00	21,932,552.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	621,300.00	2,462,287.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,980,100.00	14,031,674.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,709,700.00	4,270,000.00
210604	Урсгал засвар	11,270,400.00	9,761,674.10
2107	Томилолт, зочны зардал	3,030,500.00	7,100,000.00
210702	Дотоод албан томилолт	3,030,500.00	7,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,534,695.00	28,711,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,746,695.00	26,998,776.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	212,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,502,135.00	7,880,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,502,135.00	7,880,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	97,692,553.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	94,730,053.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,829,053.80

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,052,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,849,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,962,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,962,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,865.67	35,620,535.53
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	450,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	450,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		450,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(450,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	35,865.67	35,170,535.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		652,065.87
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	652,065.87	35,912,601.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	1,521,474,396.41	2,764,618,037.50
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	1,521,474,396.41	2,764,618,037.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	289,162.22	289,162.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	1,521,763,558.63	2,764,907,199.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(289,162.22)	-	(289,162.22)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	106,477,763.09	106,477,763.09
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,115,753.27	1,628,241,321.72	2,871,095,800.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,879,255,700.00	1,654,025,281.06	225,230,418.94	0.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,879,255,700.00	1,653,665,281.06	225,590,418.94	0.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,753,887,400.00	1,558,935,227.26	194,952,172.74	0.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,199,852,500.00	1,105,968,026.42	93,884,473.58	0.92
210101	Үндсэн цалин	723,674,900.00	601,786,151.33	121,888,748.67	0.83
210102	Нэмэгдэл	381,122,000.00	419,010,128.09	(37,888,128.09)	1.10
210104	Урамшуулал	85,172,400.00	85,171,747.00	653.00	1.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,874,400.00	135,228,453.24	13,645,946.76	0.91
210201	Тэтгэврийн даатгал	101,874,600.00	90,959,053.73	10,915,546.27	0.89
210202	Тэтгэмжийн даатгал	11,749,900.00	11,067,400.00	682,500.00	0.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,875,000.00	5,533,700.00	341,300.00	0.94
210204	Ажилгүйдлийн даатгал	5,875,000.00	5,533,700.00	341,300.00	0.94
210205	Эрүүл мэндийн даатгал	23,499,900.00	22,134,599.51	1,365,300.49	0.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,333,800.00	138,333,800.00	-	1.00
210301	Гэрэл, цахилгаан	11,910,600.00	10,194,882.82	1,715,717.18	0.86
210302	Түлш, халаалт	100,023,200.00	116,793,097.18	(16,769,897.18)	1.17
210303	Цэвэр, бохир ус	26,400,000.00	11,345,820.00	15,054,180.00	0.43
2104	Хангамж, бараа материалын зардал	76,225,700.00	42,850,183.00	33,375,517.00	0.56
210401	Бичиг хэрэг	11,916,400.00	9,288,200.00	2,628,200.00	0.78
210402	Тээвэр, шатахуун	52,125,700.00	21,883,930.00	30,241,770.00	0.42
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,175,600.00	7,405,740.00	(1,230,140.00)	1.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,370,200.00	420,000.00	950,200.00	0.31
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,637,800.00	3,852,313.00	785,487.00	0.83
2105	Нормативт зардал	112,617,900.00	78,831,564.50	33,786,335.50	0.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,389,800.00	54,436,725.00	30,953,075.00	0.64
210502	Хоол, хүнс	24,142,600.00	21,932,552.50	2,210,047.50	0.91
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,085,500.00	2,462,287.00	623,213.00	0.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,969,600.00	14,031,674.10	11,937,925.90	0.54
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	4,270,000.00	8,230,000.00	0.34
210604	Урсгал засвар	13,469,600.00	9,761,674.10	3,707,925.90	0.72
2107	Томилолт, зочны зардал	9,450,000.00	7,100,000.00	2,350,000.00	0.75
210702	Дотоод албан томилолт	9,450,000.00	7,100,000.00	2,350,000.00	0.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,863,500.00	28,711,276.00	1,152,224.00	0.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,091,000.00	26,998,776.00	92,224.00	1.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,847,000.00	1,500,000.00	347,000.00	0.81
210803	Даатгалын үйлчилгээ	240,000.00	212,500.00	27,500.00	0.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,700,000.00	7,880,250.00	4,819,750.00	0.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,700,000.00	7,880,250.00	4,819,750.00	0.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,368,300.00	94,730,053.80	30,638,246.20	0.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,368,300.00	94,730,053.80	30,638,246.20	0.76
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,690,000.00	31,829,053.80	14,860,946.20	0.68
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	59,052,000.00	59,052,000.00	-	1.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,626,300.00	3,849,000.00	15,777,300.00	0.20

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,771,881,000.00	1,585,788,232.59	186,092,767.41	0.89
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	148,963,800.00	148,963,800.00	-	1.00
132001	Орон нутгийн төсвөөс	148,963,800.00	148,963,800.00	-	1.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,622,265,200.00	1,436,824,432.59	185,440,767.41	0.89
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,622,265,200.00	1,436,824,432.59	185,440,767.41	0.89
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	33.00	4.00	0.89
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	24.00	1.00	0.96
620003	Үйлчлэх ажилтан	11.00	8.00	3.00	0.73
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.00	33.00	4.00	0.89
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	26.00	25.00	1.00	0.96
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	8.00	3.00	0.73

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,330.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулах алдааг илрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 14,330.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд төлбөрийн 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 14,330.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,149.0.4 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 3,980.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан бичгийн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1.2 Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, хуулийн 39.1-д “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид “худалдан авах гэрээ” гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.” 39.2 -д”.Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.1.3 Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй холбоотой 10,350.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”:, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 “Бараа материал”-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Дээрх шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		3,980.80				3,980.80
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,	1	0.00			1	0.00
Эм боох бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй,	1	10,350.00			1	10,350.00
Дүн	3	14,330.0	0.00	0.00	2	14,330.0